



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/35/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Г. Эрдэнэчимэг
Утас: 99016320, Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn
Ньюбаланс Аудит ХХК-ийн захирал Б. Лхагвадорж
Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com
Чанарын хяналтын менежер Д. Гэрэлчулуун
Утас: 99509636.Цахим хаяг: d.gerlee98@gmail.com
Аудиторын туслах: Д. Балжинням, Холбогдох утас:
86267997, Цахим хаяг: d.baljii73@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khvvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/2024
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЛТ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ А.ЦЭРЭНХҮҮ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>243,705,196.03</u>	<u>220,394,467.77</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	243,705,196.03	220,394,467.77
351	Түүхий эд материал	1,108,800.00	00.00
35130	Эм боох материал	1,108,800.00	00.00
354	Хангамжийн материал	241,081,396.03	218,709,467.77
35410	Бичиг хэргийн материал	15,348,750.00	12,696,350.00
35420	Аж ахуйн материал	28,803,878.50	16,770,638.50
35440	Түлш, шатах тослох материал	18,027,178.21	10,673,504.22
35450	Барилгын засварын материал	2,096,800.00	680,000.00
35460	Хүнсний материал	6,007,701.00	3,051,304.09
35470	Бусад хангамжийн материал	170,797,088.32	174,837,670.96
35600	Мал амьтад	1,515,000.00	1,685,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,387,233,566.49</u>	<u>2,539,257,281.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,387,233,566.49	2,539,257,281.29
392	Биет хөрөнгө	2,305,461,187.41	2,457,281,613.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,963,945,820.00	2,262,156,768.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-108,680,528.96	-269,513,121.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,510,000.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,510,000.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	596,506,892.11	333,145,301.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-300,797,501.05	-63,616,110.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	160,656,786.82	173,211,319.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-104,659,464.58	-79,857,265.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,626,514.16	-3,939,771.24
39217	Ном	43,921,827.23	48,500,623.23
393	Биет бус хөрөнгө	81,772,379.08	81,975,668.04
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,268,975.92	-1,065,686.96
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,630,938,762.52</u>	<u>2,759,651,749.06</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>103,000.00</u>	<u>00.00</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	103,000.00	00.00
413	Өглөг	103,000.00	00.00
4136	Бусад өглөг	103,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	103,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,630,835,762.52</u>	<u>2,759,651,749.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,630,835,762.52	2,759,651,749.06
512	Хуримтлагдсан үр дүн	186,490,557.64	315,892,404.18
51210	Өмнөх үеийн үр дүн	186,490,557.64	187,076,417.64
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	128,815,986.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,290,149,926.47	1,289,564,066.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,630,938,762.52</u>	<u>2,759,651,749.06</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,954,187,030.41	2,038,207,127.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,695,330.41	169,659,368.80
120	Нийтлэг татварын бус орлого	60,695,330.41	169,659,368.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	60,695,330.41	169,659,368.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	830,000.00	580,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,865,330.41	169,079,368.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	264,734,100.00	262,696,458.64
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,628,757,600.00	1,605,851,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,850,700.00	9,625,058.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,535,700.00	9,400,058.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	225,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	262,883,400.00	253,071,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	262,883,400.00	253,071,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,871,182,424.80	1,909,391,140.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,871,182,424.80	1,909,391,140.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,773,049,620.61	1,843,316,394.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,151,782,343.00	1,184,091,400.00
210101	Үндсэн цалин	905,366,000.00	835,761,400.00

210102	Нэмэгдэл	144,164,143.00	279,730,000.00
210104	Урамшуулал	102,252,200.00	68,600,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,458,790.00	154,249,859.00
210201	Тэтгэврийн даатгал	101,286,290.00	108,030,059.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,793,200.00	11,555,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,634,700.00	9,244,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,158,600.00	2,311,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,586,000.00	23,109,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231,972,486.00	248,836,473.99
210301	Гэрэл, цахилгаан	5,182,163.00	7,702,450.00
210302	Түлш, халаалт	225,290,323.00	240,336,473.99
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	797,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,002,036.00	30,820,448.64
210401	Бичиг хэрэг	1,147,620.00	1,369,943.64
210402	Тээвэр, шатахуун	7,750,000.00	5,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,843,500.00	1,015,400.00
210404	Ном, хэвлэл	1,592,900.00	65,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,567,500.00	1,217,815.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,154,560.00	10,700,790.00
210408	Бараа материал акталсны зардал	7,945,956.00	11,450,900.00
2105	Нормативт зардал	76,063,760.39	86,471,991.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,518,100.00	1,770,400.00
210502	Хоол, хүнс	73,545,660.39	82,076,591.94
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,625,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,839,600.00	16,786,750.00
210604	Урсгал засвар	18,839,600.00	16,786,750.00
2107	Томилолт, зочны зардал	1,340,200.00	1,373,200.00
210702	Дотоод албан томилолт	1,340,200.00	1,373,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,456,000.00	6,111,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,956,000.00	5,103,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,134,405.22	114,574,871.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,726,500.00	8,460,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,407,905.22	106,114,771.36

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,132,804.19	66,074,745.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,105,946.19	51,427,280.97
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,771,946.19	51,017,280.97
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,334,000.00	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	70,209,021.00	14,647,465.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	70,209,021.00	14,647,465.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	817,837.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	817,837.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	83,004,605.61	128,815,986.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	87,786.58	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	87,786.58	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-87,786.58	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	82,916,819.03	128,815,986.54

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	1,154,195,278.41	1,290,149,926.47	186,490,557.64	2,630,835,762.52
D01	2021 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл	1,154,195,278.41	1,290,149,926.47	186,490,557.64	2,630,835,762.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	585,860.00	585,860.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,154,195,278.41	1,290,149,926.47	187,076,417.64	2,631,421,622.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-585,860.00	00.00	-585,860.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	128,815,986.54	128,815,986.54

D09	2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	1,154,195,278.41	1,289,564,066.47	315,892,404.18	2,759,651,749.06
-----	--	------------------	------------------	----------------	------------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,893,491,700.00	1,868,547,758.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,893,491,700.00	1,868,547,758.64
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,628,757,600.00	1,605,851,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,850,700.00	9,625,058.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,535,700.00	9,400,058.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	225,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	262,883,400.00	253,071,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	262,883,400.00	253,071,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,824,977,282.00	1,775,550,458.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,824,977,282.00	1,775,550,458.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,731,170,561.00	1,709,780,843.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,151,679,343.00	1,184,194,400.00
210101	Үндсэн цалин	905,263,000.00	835,864,400.00
210102	Нэмэгдэл	144,164,143.00	279,730,000.00
210104	Урамшуулал	102,252,200.00	68,600,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,458,790.00	154,249,859.00
210201	Тэтгэврийн даатгал	101,286,290.00	108,030,059.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,793,200.00	11,555,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,634,700.00	9,244,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,158,600.00	2,311,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,586,000.00	23,109,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	238,932,663.00	241,482,800.00
210301	Гэрэл, цахилгаан	5,182,163.00	7,702,450.00
210302	Түлш, халаалт	232,250,500.00	232,982,800.00

210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	797,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,469,800.00	18,908,958.64
210401	Бичиг хэрэг	1,383,500.00	1,658,843.64
210402	Тээвэр, шатахуун	7,750,000.00	5,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,918,500.00	1,015,400.00
210404	Ном, хэвлэл	1,656,900.00	65,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,058,200.00	1,742,815.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,702,700.00	9,426,300.00
2105	Нормативт зардал	105,658,720.00	82,988,826.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,551,300.00	661,600.00
210502	Хоол, хүнс	62,971,820.00	79,015,326.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	35,135,600.00	3,311,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,083,045.00	13,718,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,950,145.00	2,130,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	23,132,900.00	11,588,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,340,200.00	1,373,200.00
210702	Дотоод албан томилолт	1,340,200.00	1,373,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,456,000.00	6,111,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,956,000.00	5,103,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,092,000.00	6,752,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,092,000.00	6,752,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,806,721.00	65,769,615.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,779,863.00	51,122,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,445,863.00	51,122,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,334,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	70,209,021.00	14,647,465.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	70,209,021.00	14,647,465.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	817,837.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	817,837.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>68,514,418.00</u>	<u>92,997,300.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>

4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	68,514,418.00	92,997,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	68,514,418.00	92,997,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	68,514,418.00	92,997,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	68,514,418.00	92,997,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-68,514,418.00</u>	<u>-92,997,300.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,858,922,700.00	1,844,275,235.00	14,647,465.00	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,858,922,700.00	1,844,275,235.00	14,647,465.00	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,803,111,600.00	1,793,153,085.00	9,958,515.00	99.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,184,194,400.00	1,184,194,400.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	835,864,400.00	835,864,400.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	279,730,000.00	279,730,000.00	0.00	100.0
210104	Урамшуулал	68,600,000.00	68,600,000.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	154,898,500.00	154,249,859.00	648,641.00	99.6
210201	Тэтгэврийн даатгал	108,678,700.00	108,030,059.00	648,641.00	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	11,555,000.00	11,555,000.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,244,000.00	9,244,000.00	0.00	100.0

Хөвсгөл аймгийн Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	2,311,000.00	2,311,000.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,109,800.00	23,109,800.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	241,482,800.00	241,482,800.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,500,000.00	7,702,450.00	-202,450.00	102.7
210302	Түлш, халаалт	232,982,800.00	232,982,800.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	797,550.00	202,450.00	79.8
2104	Хангамж, бараа материалын зардал	17,981,200.00	17,981,200.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	915,400.00	915,400.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	915,400.00	915,400.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	762,900.00	762,900.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	961,200.00	961,200.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,426,300.00	9,426,300.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	91,998,700.00	82,988,826.00	9,009,874.00	90.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	661,600.00	661,600.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	88,025,200.00	79,015,326.00	9,009,874.00	89.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,311,900.00	3,311,900.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91,588,600.00	91,588,600.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	65,000,000.00	65,000,000.00	0.00	100.0
210602	Тавилга	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	11,588,600.00	11,588,600.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,480,000.00	1,373,200.00	106,800.00	92.8
210702	Дотоод албан томилолт	1,480,000.00	1,373,200.00	106,800.00	92.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,084,600.00	4,891,400.00	193,200.00	96.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	4,076,600.00	3,883,400.00	193,200.00	95.3

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14402800.00	14402800.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,402,800.00	14,402,800.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55811100.00	51122150.00	4,688,950.00	91.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,811,100.00	51,122,150.00	4,688,950.00	91.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,811,100.00	51,122,150.00	4,688,950.00	91.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,858,922,700.00	1,844,275,235.00	14,647,465.00	99.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,605,851,300.00	1,591,203,835.00	14,647,465.00	99.1
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,605,851,300.00	1,591,203,835.00	14,647,465.00	99.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	253,071,400.00	253,071,400.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	253,071,400.00	253,071,400.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	97.00	97.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	61.00	61.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	35.00	35.00	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,241.00	1,241.00	0.00	100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,241.00	1,241.00	0.00	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	1,241.00	1,241.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	97	97	0.00	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	62	62	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	35	35	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,625,058.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,625,058.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,625,058.64
2104	Хангамж, бараа материалын зардал	1,625,058.64
210401	Бичиг хэрэг	743,443.64
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	781,615.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9625058.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,625,058.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,400,058.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	225,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Б. Лхагвадорж, аудиторын туслах Д. Балжинням нар гүйцэтгэж, хяналтыг аудитын чанарын менежер Д. Гэрэлчулуун гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г. Ичинхорлоо, аудитын менежер Э. Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А. Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн № 03 тоот албан бичгээр ирүүлсэн.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Галт сумын Ерөнхий боловсролын сургууль хамран сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжил оролцоог дээшлүүлэх, амьдрах чадвартай “Зөв хүүхэд”

төлөвшүүлэх, боловсон хүчний нөөц, чадавхийг чанаржуулах, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн хамт олон байх зорилго дэвшүүлэн ажиллаж буй хичээл сургалтын үйл ажиллагаа эрхлэх улсын төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг өөрчилсөн, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хавсралтаар шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,871.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 37.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 28.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 128.7 сая төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	243.7	220.4	-23.3
Биет хөрөнгө	2,305.5	2,457.3	151.8
Биет бус хөрөнгө	81.8	82.0	0.2
Нийт хөрөнгө	<u>2,631.0</u>	<u>2,759.7</u>	128.7
Дансны өглөг	0.1	0.0	-0.1
Засгийн газрын хувь оролцоо	1,154.2	1,154.2	0.0
Хуримтлагдсан үр дүн	186.5	315.9	129.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,290.2	1,289.6	-0.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>2,631.0</u>	<u>2,759.7</u>	128.7

Бараа материалын дансны үлдэгдэл 220.4 сая төгрөг болж, 23.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд урсгал засварын материал, хоолны материалын үлдэгдлээс зарцуулсан, мөн данснаас 11.5 сая төгрөгийн хөрөнгө актаар хассан нь үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,539.2 сая төгрөг болж, 151.8 сая төгрөгөөр өссөн нь БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 32.0 сая төгрөгийн зөөврийн компьютер, сурагчийн ширээ, сандал, гал тогооны цахилгаан тогоо, 3.9 сая төгрөгийн сурах бичиг, “Багшийн хөгжил төв”-д 17.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил хүлээн авсан. Төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр 93.0 сая төгрөгийн эд хөрөнгө худалдан авсан. Үндсэн хөрөнгийн данснаас цаашид ашиглах боломжгүй, элэгдлээ нөхсөн эд хөрөнгийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 109 дүгээр тогтоол, Галт сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 22 дугаар тогтоол, 2021 оны 35 дугаар тогтоолоор тус тус нийт 26.0 сая төгрөгийн эд хөрөнгийг акталж, аймгийн ИТХ-ын 111 дүгээр тогтоолоор 108 нэр төрлийн 500 ш эд хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосноор 111.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвийн санхүүжилт 22.9 сая төгрөгөөр буурч, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 109.2 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оныхоос 38.2 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бусад урсгал шилжүүлэг зэрэг зардлууд өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд хөрөнгийн ашиглах жил болон үнийг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор дахин үнэлгээ хийгдсэн 0.6 сая төгрөгийн эд хөрөнгө хасагдсан. Уг дүнгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хуримтлагдсан үр дүнд өөрчлөлт орсон байна. Дансны өглөг данс үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 1,154.2 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 315.9 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 1,289.6 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2,038.2 сая төгрөг, нийт зардал 1,909.4 сая төгрөг, тайлант үеийн үр дүн 128.8 сая төгрөг байна. Нийт цэвэр өмчийн дүн 2,759.6 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,217.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,217.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 501.2 сая төгрөгөөр бууруулж, 1,716.3 сая төгрөгөөр төсвийг баталсан байна.

Галт сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар төсвийн орлогыг 1,716.3 сая төгрөгөөр, зарлагыг 1,716.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн жилийн явцад 1 удаа тодотгол хийсэн байна.

Мөн Галт сумын ИТХ-ын хуралдааны 2021 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор 1.3 сая төгрөгийн төсвийг нэмж тодотгол хийгдсэн байна. Үүнд: Цалингийн зардалд 1.2 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 0.1 сая төгрөг нэмсэн. Төсвийн зохицуулалтыг аймгийн Засаг даргын 2021 оны А/608 дугаар захирамжаар гэрэл цахилгааны зардлаас 6.5 сая төгрөг, түлш халаалтын зардлаас 18.0 сая төгрөг, цэвэр бохир усны зардлаас 1.0 сая төгрөг, хоолны зардлаас 88.0 сая төгрөгийг хасаж, дотоод томилолтын зардалд 0.1 сая төгрөг, төлбөр хураамж бусад зардалд 2.1 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 1.0 сая төгрөг, багаж хэрэгслийн зардалд 60.0 сая төгрөг, тавилга, эд хогшил авах зардалд 15.0 сая төгрөг, аудитын төлбөр хураамжийн зардалд 0.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,858.9 сая төгрөгийн төсөв баталсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,591.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 253.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,844.3 сая төгрөгийг зарцуулж, 14.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,844.3 сая төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.6 сая төгрөгөөр, хоол, хүнсний зардлыг 9.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 0.3 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг 4.7 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Сургуулийн хэмнэгдсэн зардлыг зарцуулах талаар Боловсролын сайдын 2021 оны 1а/6368 тоот албан бичиг, аймгийн Боловсролын газрын даргын 2021 оны 401 дүгээр тушаалаар ерөнхий чиглэл өгсөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвөөс 10 хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Галт сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 9.4 сая төгрөг, гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааны орлого 0.2 сая төгрөг, нийт 9.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/280 дугаар тушаалаар “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн хүрээнд 8.0 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил үйлчилгээний зардалд, бичиг хэргийн зардалд 0.7 сая төгрөг, хог хаягдал, хортон шавьж устгах зардалд 0.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, хөл хорионы үед хүүхдийн цэцэрлэгүүд хичээллэхгүй байх, мөн хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэл үүссэн. Ковидтой холбоотой төсвийн хэтрэлт, хэмнэлт гарч, Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн "Аймгийн 2021 оны төсөвт тодотгол хийх тухай" 01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/608 дугаар захирамжаар төсвийн зохицуулалт хийгдсэн.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын явцад үлэмж нөлөө үзүүлэх асуудал үүсээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Галт сумын Ерөнхий боловсролын сургуулийн тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 149 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим захиргааны хэм хэмжээний актын нийцлийн хэрэгжилтийг хянан үзлээ. Үүнд: Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт тус тус нийцсэн эсэхийг дүгнэн үзсэн болно. Монгол Улсын Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосугай.” гэж, 2-д “...6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1800 (нэг мянга найман зуун) төгрөг байхаар тогтоож...” гэж тус тус заасныг мөрдөн ажилласан байна. Мөн Засгийн газрын

“Хоолны зардлын норматив тогтоох тухай” 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 (Гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай.” гэж заасныг дагаж мөрдөж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, акт, албан шаардлага байхгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны төсвийн захирагч нарын 2021 онд төсвийг зохицуулан шийдвэрлэсэн шийдвэрийн нийцлийг авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ

БЭЛТГЭСЭН:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Б.ЛХАГВАДОРЖ

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

Д.ГЭРЭЛЧУЛУУН

АУДИТОРЫН ТУСЛАХ

Д. БАЛЖИННЯМ